



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 05 сарын 19 өдөр

Дугаар 273

Улаанбаатар хот

Төрийн болон орон нутгийн өмчид
эд хөрөнгө бүртгэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2020 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн 9 дүгээр тэмдэгэл, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1.а дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Оросын Холбооны Улсын өмчөөс Монгол Улсын өмчид шилжүүлсэн хөрөнгийг төрийн өмчид хүлээн авч, хавсралтад заасны дагуу төрийн болон орон нутгийн өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дэд дарга А.Дагвадорж, Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын үүрэг гүйцэтгэгч Ш.Үнэнбат, Дархан-Уул аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга М.Хүрэлбаатар, “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн захирал Д.Баярсайхан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах,

2.2. Хөрөнгийн байршил, зориулалтыг харгалзан, эзэмшигч байгууллагыг тогтоох асуудлыг аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулан шийдвэрлүүлэх;

2.3. Хөрөнгийг санхүүгийн тайлагналыг зориулалтаар үнэлж, бүртгэлд тусгах, үл хөдлөх хөрөнгөд хамаарах газар эзэмших эрхийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу байгууллагын нэр дээр баталгаажуулах ажлыг зохион байгуулах;

2.4. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.5. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.НАРАНГЭРЭЛ



300451

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
 газрын 2020 оны 05 дугаар сарын
 19-ний өдрийн 273 дугаар тогтоолын хавсралт

**Оросын Холбооны Улсын өмчөөс Монгол Улсын өмчлөлд үнэ төлбөргүй
 шилжүүлэн авсан, төрийн болон орон нутгийн өмчид бүртгэх үл хөдлөх эд
 хөрөнгийн жагсаалт**

№	Үл хөдлөх эд хөрөнгийн объектын нэр	Хаяг (Объектын байршил)	Объектын талбай (м.кв)	Хүлээн авч, данс бүртгэлд тусгах хуулийн этгээдийн нэр
1	2	3	4	5
1	Трансформаторын барилга № 1	Монгол Улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 4-р хороо, 15-р хороолол (13343), Лхагвасүрэнгийн гудамж ТП 12/1	57.20	<u>“Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК</u>
2	Дэд станц /ЦТП/ № 1	Монгол Улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 4-р хороо, 15-р хороолол (13343), Лхагвасүрэнгийн гудамж ЦТП 6	110.90	<u>Нийслэлийн өмчийн харилцааны газар, Орон сууцны контор</u>
3	Дэд станц /ЦТП/ № 2	Монгол Улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 5-р хороо, 15-р хороолол (13343), Энх тайвны өргөн чөлөө ЦТП 7/1	110.90	<u>Нийслэлийн өмчийн харилцааны газар, Орон сууцны контор</u>
4	Трансформаторын барилга № 2	Монгол Улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 5-р хороо, 15-р хороолол (13343), Рерихийн гудамж, ТП 17/1	57.20	<u>“Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК</u>
5	Трансформаторын барилга	Монгол Улс, Дархан-Уул аймаг, Дархан сум, 4-р багийн засаг захиргааны нэгж	41.67	<u>Дархан-Уул аймгийн Орон нутгийн өмчийн газар</u>
6	Трансформаторын барилга (сургуулийн)	Монгол Улс, Дархан-Уул аймаг, Дархан сум, 5-р багийн засаг захиргааны нэгж	41.67	<u>Дархан-Уул аймгийн Орон нутгийн өмчийн газар</u>